

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТЭД САНАЛ, ДҮГНЭЛТ ӨГӨХ ХУУДАС

2024 оны 12 дугаар сарын 23-ны өдөр

Дархан-Уул аймаг

Д/д	Сумын Засаг даргын гэрээний биелэлт	Зорилтын тоо	Арга хэмжээ тоо	Өөрийн үнэлгээ	Харьяа бодлогын хэлтсийн үнэлгээ
1.	ДХББЗГ ОНӨААТҮГ	2	12	98,8%	96,4%
Санал, дүгнэлт, зөвлөмж: - ЗДҮАХ-ийн 1.3.2.. Шинээр барих, өргөтгөх замаар цэцэрлэг, сургуулийн тоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд СӨБ, ЕБС-тай хамтран ажиллах /хяналтыг хамтран хэрэгжүүлэх/ - БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДААС ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ 20 дугаар зүйл: Орон сууцны болон бусад төрлийн барилгын норм, нормативын баримт бичгийн мөрдүүлэлт, чанар, аюулгүй байдлыг сайжруулах, мөн Барилга байгууламжийн зураг төсөл, ажлын даалгаварт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай шаардлага, холбогдох норм ба дүрэм, стандартуудыг тусгаж, хэрэгжүүлэхэд хяналт тавьж хэрэгжүүлэх - Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд гүйцэтгэгч байгууллагуудтай хамтран ажиллах					

САНАЛ, ДҮГНЭЛТ ӨГСӨН:

ТАНИЛЦСАН: ХБТХОХ-ИЙН ДАРГА

ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



П.БАТСҮХ

Б.БУЯНБАТ

**“ДАРХАН-ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР” ОНӨААТҮГ-ЫН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

2024.12.09

Дархан-Уул аймаг

Д/д	Зорилт	2024 онд төлөвлөсөн арга, хэмжээ	2024 оны хэрэгжилт /жилийн эцэс/	Гүйц/хувь	ХШҮДА хариуцсан ажилтны үнэлгээ	Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн даргын үнэлгээ
Стратеги төлөвлөгөөний зорилго №1 Захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлэх						
1	Зорилт №1 Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 151 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэх	1.1.Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах 64 төсөл арга хэмжээ	2024 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 2023-2024 онд шилжсэн 35.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл, арга хэмжээ, 2024 онд шинээр хэрэгжиж буй 79.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 75 төсөл буюу нийт 114.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 94 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлэн ажиллаж 40.7 тэрбум төгрөгийн 117 гүйцэтгэлийг баталгаажуулсан байна. Үүнээс байнгын ашиглалтад 76 төсөл, арга хэмжээг хүлээлгэн өгсөн. 2025 онд 18 төсөл, арга хэмжээ шилжин хэрэгжинэ.	100%	97	94
		1.2.Инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах 13 төсөл, арга хэмжээ	2024 оны жилийн эцэст 2023-2024 онд шилжсэн 23.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 төсөл арга хэмжээ, 2024 онд шинээр хэрэгжиж буй 10.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл буюу нийт 33.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 27 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж 9.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 24 гүйцэтгэлийг хянан баталгаажуулан ажиллалаа. Үүнээс байнгын ашиглалтад 18 төсөл, арга хэмжээг хүлээлгэн өгсөн. 9 төсөл, арга хэмжээ шилжин хэрэгжинэ.	100%	98	94
		1.3.Авто зам, зогсоол шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах 60 төсөл, арга хэмжээ	2024 оны жилийн эцсийн байдлаар зам, замын байгууламжийн 2023-2024 онд шилжин хэрэгжиж байгаа 27,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээ, 2024 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 59.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл, арга хэмжээ, нийт 87.1	100%	98	94

			тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж 30.0 тэрбум төгрөгийн 120 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна. Үүнээс байнгын ашиглалтад 66 төслийг хүлээлгэн өгсөн ба 2025 онд 12 төсөл, арга хэмжээ шилжин хэрэгжинэ.			
		1.4.Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн нийт 13 төсөл, арга хэмжээ	2023-2024 онд шилжин хэрэгжиж буй 29,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл, арга хэмжээ 2024 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 23.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл буюу нийт 23.9 тэрбум төгрөгийн төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөлд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техник хяналт хэрэгжүүлж 6.3 тэрбум төгрөгийн 14 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж ажиллалаа. Үүнээс байнгын ашиглалтад 10 төсөл арга хэмжээг хүлээлгэн өгсөн. 2025 онд 5 төсөл, арга хэмжээ шилжин хэрэгжинэ.	100%	99	94
		1.5.2024 онд хэрэгжүүлэх 151 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн төсөв хянан баталгаажуулах	2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 258.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 214 төсөл, арга хэмжээнд техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 86.6 тэрбум төгрөгийн 276 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна. Төсвийн хэмнэлт: -Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаснаар магадлашгүй ажлын зардлаас 140.1 сая төгрөг -Инженерийн оночвтой шийдэл гаргаснаар хийгдээгүй ажлын зардлаас: 42.2 сая төгрөг -Зураг төсөл, зохиогчийн хяналтын зардлаас 3.7 сая төгрөг НӨАТ-39.7 сая төгрөг Нийт 225.9 сая төгрөг	100%	100	98
Хэсгийн дүн				100%	98.4 %	94.8 %
Зорилт №2 Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх						
2	2.1.Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, газрын сургалтын төлөвлөгөөний	2.1.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах	2024 оны батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн 11 гэрээгээр 2 ажилтан ажилд аван нийт 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. Бүтээн байгуулалтын ажилд багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай мэргэшсэн инженерүүдийг томилон ажиллуулж байна.	100%	97	95

дагуу сургалт зохион байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх		➤ Зөвлөх инженер-1 хүн ➤ Мэргэшсэн инженер-1 хүн ➤ Мэргэшсэн нягтлан бодогч-1 хүн ➤ Ахлах инженерийн сертификаттай 1 хүн ➤ Магистр зэрэгтэй 2 хүн, бакалавр зэрэгтэй 11 хүн			
	2.1.2.Сургалтын хэрэгцээг тодорхойлж, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах.	2024 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ИТА, албан хаагчид нь мэдлэг мэргэшлээ дээшлүүлэн суралцсан. • Мэргэжил дээшлүүлэх сургалтад 3 хүн • Байгууллагын дотоод сургалтад-37 удаа • Бусад-9 удаа	100%	98	96
2.2.Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх	2.2.1.Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх	Мэдээ тайлан гаргасан байдал: Барилгын хөгжлийн төвд, Аймгийн ЗДТГ ын ХБТХОХ, ТЗУХ, ХШУХ, ОНӨГ, Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газар, Статистикийн хэлтэс зэрэг холбогдох газруудад тайлан мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.	100%	100	96
	2.2.1.Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах	Аймгийн ИТХ, Аймгийн Засаг дарга, Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, Дархан ТУН, Барилгын хөгжлийн төв, Аймгийн ГХБХБГ зэрэг төр захиргааны байгууллагуудад цаг хугацаанд нь мэдээллээр хангаж ажиллалаа.	100%	100	99
2.3.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.	2.3.1 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлгийн 215 төслийн ажлын явцын мэдээ, мэдээллийг 251 удаа олон нийтэд мэдээлсэн ба байгууллагын цахим хуудаст байршуулсан барилга угсралтын төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээлэл нь 92,103 хүнд хүрсэн үзүүлэлттэй байгаа ба 1212 хүн таалагдсан товчийг дарж, 757 удаа өөрийн цахим хуудаснаа хувцаалцжээ. 43 хүн сэтгэгдэл бичиж, 1916 хүн дагасан үзүүлэлттэй байна.	100%	98	96
2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	2.4.1 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Усан хангамж, ариутгах татуургын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох тогтоол, захирамж, тушаал шийдвэр, одоо мөрдөгдөж байгаа БНБД стандартуудын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа	100%	100	100

			мөрдөж ажиллалаа. Газрын дарга нь А тушаал-125ш, Б тушаал 61ш гаргасан ба ИТА, албан хаагчид тушаал, шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа. 2024 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 953ш албан бичгийг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба ААН, байгууллагууд руу 820ш албан бичгийг хүргүүлж ажилласан байна.			
2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах.	2.5.1 Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан үйл ажиллагаа явуулах.	2024 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу байр ашиглалттай холбоотой зардал 8.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 27.3 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 60.2 сая төгрөг, цалингийн зардал 382.5 сая төгрөг, томилолтын зардал 4.5 сая төгрөг, сургалтын зардал 1.2 сая төгрөг, бусад ажил үйлчилгээ, татвар хураамжийн зардалд 284.6 сая төгрөг, зохиогчийн хяналт болон геодезийн хяналтын зардалд 154,1 төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 922.8 сая төгрөг зарцуулж 950,0 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэн ажилласан байна.	100%	100	100	
	2.5.2 Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж ажилласан. 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг "Пийк ом аудит" ХХК-иар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлттэй. Холбогдох газруудад санхүүгийн мэдээ тайланг цаг хугацаанд нь гарган хүргүүлсэн. 2024 оны санхүүгийн тайланд аудит Пийк ом ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.	100%	100	95	
	2.5.3 Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.	2024 онд борлуулалтын орлогыг 950,0 сая төгрөгөөр бүрдүүлсэн ба үйл ажиллагааны зардалд 922,8 сая төгрөгийг зарцуулсан. Татвар, ногдол ашгийн өглөгийг бууруулсан. Аймгийн төсөвт 6,8 сая төгрөгийн ноогдол ашгийг АЗДТГ-т төвлөрүүлнэ.	100%	100	98	

		2.5.4 Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах	Газрын өмч хамгаалах зөвлөл нь 8 удаа хуралдаж үндсэн хөрөнгө худалдан авах, тооллого зохион байгуулах, сэлбэг хэрэгсэл худалдан авах, үндсэн хөрөнгө актлах зэрэг шийдвэрүүдийг гаргаж газрын даргад танилцуулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. 2024 оны жилийн эцсийн тооллогоор 180.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон. Өмнөх жилийн эцсийн тооллогоос өссөн үзүүлэлттэй байна. Учир нь 2024 онд барилга угсралт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдсэнтэй холбоотойгоор ИТА, албан хаагчдын хэрэгцээнд 54.9 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө худалдан авч, 9.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталж данснаас хассан.	100%	100	100
2.6 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.	2.6.1.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах	Улсын комиссоор ашиглалтад оруулсан барилга байгууламжуудад гарсан зөрчлийг ашиглагч байгууллагуудаас ирсэн гомдол, саналыг үндэслэж гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаат хугацаанд нь засварлуулах ажлыг хяналт гүйцэтгэж байсан инженерүүдээр хариуцуулан гүйцэтгүүлсэн. Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газраас хяналт шалгалт хийж 7ш зөрчил дутагдлуудыг гүйцэтгэгч байгууллагаар хугацаанд нь арилгуулж тайланг хүргүүлсэн.	100%	98	97	
	2.6.2.Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх.	2024 оны гүйцэтгэлийн тайланг гарган аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т, 2023 оны объект тус бүрийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын ХШҮ-ний тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн.	100%	100	100	
Хэсгийн дүн				100%	99.2	
Нийт дүн				100%	98.8 %	96,4%

Дүгнэлт:

“ДХББЗГ” ОНӨААТҮГ нь 2024 онд 151 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган ажилласан ба жилийн эцсийн байдлаар 258.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 214 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж 170 төсөл, арга хэмжээг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2025 онд 44 төсөл, арга хэмжээ шилжин хэрэгжинэ.

Зорилт №1 стратеги төлөвлөгөөний 5 арга хэмжээ, Зорилт №2 стратеги төлөвлөгөөний 12 арга хэмжээнд буюу удирдлагын үйл ажиллагаа, инженерүүдийн үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд тус тусад нь үнэлэхэд нийт үнэлгээгээр *96,4%* тай буюу ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.

Үнэлгээ хийсэн:
Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн Дарга

(П.Батсүх)

Танилцаж зөвшөөрсөн:
Дарга

(Д.Батбаяр)

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажилтан:
Ерөнхий инженер

(У.Заяахүү)

